

# Арлингтоны улсын сургууль СУРАГЧИЙГ ДЭМЖИХ ПРОЦЕСС

Арлингтоны улсын сургууль (АУС) нь сурагчдыг дэмжих боловсронгуй процесстэй. Бид гэр бүлийн оролцооны ач холбогдлыг хүлээн зөвшөөрч үнэлдэг бөгөөд танд Сурагчийг дэмжих үйл явц, мөн хүүхдийнхээ сурлага, нийгэмшил, сэтгэл санааны болон зан байдлын хэрэгцээ шаардлагатай холбоотой асуудлаар санаа зовж байвал сургуультай хэрхэн хамтарч ажиллах арга замыг мэддэг байгаасай гэж хүсэж байна. Багш ажилтнууд сурагчидтай ажиллахдаа баримталдаг журмыг доор харуулав.

## ҮЕ ШАТ 1

### БАГШ



### Сурагчийг дэмжих үйл явцын үе шат 1

Аливаа сурагчийн сурлага, нийгэмшил, хүмүүжил эсвэл зан байдлын талаар асуудал үүсвэл багш гэрийнхэнд нь хэлж, ангид нь тусламж дэмжлэг үзүүлж эхэлдэг. Багш тусгайлан заах, дэмжлэг үзүүлэх, ахиц дэвшлийг хянах, дараагийн арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд мэдээллийг ашигладаг.

## ҮЕ ШАТ 2

### ХАМТЫН СУРГАЛТ / БАГШИЙН БАГ (ХСББ)



### Сурагчийг дэмжих үйл явцын үе шат 2

Хэрэв сурагч тусламж дэмжлэг авсан ч зохих ахиц дэвшил гаргахгүй байгаа бол багш сургуулийн хамтран ажилладаг багтай ярилцаж, нэмэлт мэдээлэл авч, илүү туслалцаа үзүүлэх талаар судлахын тулд сурагчийн гэр бүлийнхэнтэй холбоо барина. Тус баг ахиц дэвшлийг хянаж, дараагийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай эсэхийг тодорхойлно. Баг сурагчид туслах үйл ажиллагааг үргэлжлүүлэх, туслалцааг өөрчлөх эсвэл Сурагчийг дэмжих баг руу шилжүүлэх эсэх талаар шийдвэр гаргаж болно.

## ҮЕ ШАТ 3

### СУРАГЧИЙГ ДЭМЖИХ БАГ (СДБ)

- Туслах төлөвлөгөө
- Тусгай боловсролын үнэлгээ
- Хэсэг 504 Ажиглалт



### Сурагчийг дэмжих үйл явцын үе шат 3

Хэрэв сурагчид туслах үйл ажиллагааг дор хаяж 5-6 долоо хоногийн туршид тууштай хэрэгжүүлсэн бөгөөд сурагч зохих ахиц дэвшил гаргаагүй бол сургууль бүрд байдаг багш эцэг эх/асран хамгаалагчийн оролцоотой, Сурагчдыг дэмжих зохицуулагчийн (СДЗ) ахалдаг Сурагчийг дэмжих багт энэ тухай (СДБ) мэдэгдэнэ. СДБ тодорхойлолттой танилцаж, сурагчид туслах үйл ажиллагаанаас гарсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, залруулах илүү албан ёсны төлөвлөгөө боловсруулах эсвэл Тусгай боловсролын үнэлгээ хийлгүүлэх эсвэл Хэсэг 504-н дагуу Ажиглалтад хамруулах зэрэг дараагийн арга хэмжээг тодорхойлдог.



Эцэг эх/асран хамгаалагч мөн сурагчид дэмжлэг үзүүлэх процессыг эхлүүлж болно. Хэрэв та хүүхдийнхээ сурлага, нийгэмшил, хүмүүжил эсвэл зан байдлын талаар санаа зовж байгаа бол хамгийн түрүүнд хүүхдийнхээ багштай шууд уулзаж ярилцах хэрэгтэй. Мөн та тусгай боловсролын үнэлгээ хийлгэх ба/эсвэл хөгжлийн бэрхшээлтэй гэж үзэж буй тохиолдолд Хэсэг 504-н дагуу шалгуур хангах эсэхийг тодорхойлохоор Сурагчийг дэмжих багийн уулзалт хийлгэх хүсэлт гаргаж болно. Эцэг эхчүүд Эцэг эхийн мэдээллийн төвтэй [prc@arpsva.us](mailto:prc@arpsva.us) хаягаар эсвэл 703-228-7239 дугаараар холбогдон асуулт асуух, нэмэлт мэдээлэл авах боломжтой.